

**“АВТОЗАМ, ТӨМӨР ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ БОЛОН ГҮҮРЭН БАЙГУУЛАМЖИД
ХОЛБООНЫ КАБЕЛЬ ШУГАМЫГ СУУРИЛУУЛАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА MNS
6597:2016” СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

<p>Боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага</p>	<p>Уг стандарт нь 2016 онд батлагдсан бөгөөд холбооны кабель шугамын угсралт суурилуулалтын ажлыг хийхдээ авто зам, төмөр зам болон гүүрэн байгууламжийг дайран гарахад тавигдах ерөнхий шаардлагыг тогтоосон байдаг.</p> <p>Гэвч холбооны кабель шугамыг шинээр барьж байгаа авто замыг төлөвлөхдөө холбооны кабель сүвлэж гаргах хоойлой суурилуулахаар хийгддэггүй ба үүнээс үүдээд замыг дараа нь сэтлэх, хоолой буудах зэргээр зардал, хүн хүч, цаг хугацаа зарцуулагддагаас гадна замыг сэтэлснээр замын хийц, технологид өөрчлөлт оруулах эрсдэл үүсдэг.</p> <p>Түүнчлэн кабелийг гол хөндлөн гүүрээр гаргахдаа зориулалтын бус, чанаргүй труба ашигласнаар амархан эвдрэх, хагарах, зэврэх, хөлдөх, бэхэлгээг муу хийснээс гүүрэн дээрх замын хөдөлгөөнөөс болж яндан унах, хугарах, эдгээрээс үүдэн кабель ил гарах, унжих, тасрах, хулгайд алдагдах, ашиглалт үйлчилгээ доголдох, аюулгүй ажиллагаа зөрчигдөх, хүний ам насанд аюул учрах эрсдэл үүсч байна.</p> <p>Иймд сүлжээ, үйлчилгээний чанарын шаардлагууд, тасралтгүй, найдвартай ажиллагаа, ашиглалт үйлчилгээний үеийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагуудыг уг стандартад нэмж тусгах шаардлагатай байна.</p>
<p>Стандартын хамрах хүрээ /стандартаар юуг тодорхойлох, зайлшгүй тусгах, шинэчлэх шаардлагууд/</p>	<p>Холбооны кабель шугамыг авто зам, төмөр зам дагуу болон хөндлөн гаргах, гүүрэнд бэхлэн гол хөндлөн гаргахад ашиглах технологиуд /гүүр ба замын хийц, бүтэц, төрөл, хэмжээ, байгалийн үзэгдэл, хөрс шороо, ус чийг, бусад дэд бүтэцтэй зээргцсэн, огтолцсон байдал зэргээс хамаарсан/, труба, бэхэлгээ, дагалдах тоноглол, багаж, хэрэгсэл, ашиглалт үйлчилгээ /кабелийн залгаа гэх мэт/ хийх зориулалтын хэсэг, тэдгээрийн болон кабель шугамын суурилуулалт, ашиглалт үйлчилгээнд тавигдах шаардлагууд, холбогдох үзүүлэлт, хэмжээс, тэмдэглэгээнүүд</p>
<p>Стандартыг хаана мөрдөх</p>	<p>Авто зам, төмөр зам, гүүр болон мэдээлэл холбооны сүлжээг төлөвлөх, байгуулах, ашиглалт, үйлчилгээ явуулах, шалгаж хүлээж авах, хяналт тавихад хамаарна.</p>
<p>Стандарттай уялдуулах хууль тогтоомж, үндэсний болон олон улсын стандартууд, бусад холбогдох баримт бичгүүд</p>	<p>Харилцаа холбоо болон барилга, зам тээврийн салбарт мөрдөгдөж буй олон улсын болон үндэсний стандарт, норм дүрэм, зөвлөмжүүд, бусад холбогдох хууль, дүрэм журам, баримт бичгүүд, тэдгээрт тусгасан нэр томъёо, тодорхойлолтууд</p>